



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 10 нэрийн 5,537,753,082.00 (таван тэрбум таван зуун гучин долоон сая долоон зуун тавин гурван мянга наян хоёр) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ



0000166

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын
газрын 2020 оны 03 дугаар сарын 10-ны
өдрийн 70 дугаар тогтоолын
хавсралт

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон барилга
байгууламжийг бүртгэх хөрөнгийн жагсаалт**

Д/д	Хөрөнгийн нэр, марк дугаар	Ашигл алтад орсон он	хүчин чадал		Нийт үнэ (төгрөгөөр)	Хүлээн авч ашиглах төсөвт байгууллагын нэр
			хэм жих нэгж	биет хэм жээ		
1	Лабораторийн барилга	2019	м2	504	886,399,397.00	Сайншанд дахь гаалийн газар
2	Гадна зам талбай	2019			88,547,134.00	
3	Гадна шугам сүлжээ	2019			197,525,469.00	
4	Лабораторийн барилга	2019	м2	252	686,297,861.00	Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар
5	Гадна зам талбай	2019			33,261,948.00	
6	Гадна шугам сүлжээ	2019			78,840,191.00	
7	Лабораторийн барилга	2019	м2	504	784,918,442.00	Орхон аймаг дахь гаалийн газар
8	Гадна зам талбай	2019			195,904,335.00	
9	Гадна шугам сүлжээ	2019			67,794,305.00	
10	конторын барилга	2019	м2	1500	2,338,264,000.00	Замын-Үүд дэх гаалийн газар
					5,357,753,082.00	
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН				5,537,753,082.00 (таван тэрбум таван зуун гучин долоон сая долоон зуун тавин гурван мянга наян хоёр)	